

МИНИЙ МЭДЭХ ОЮУ ТОЛГОЙ

*ШУТИС-ийн Механик Инженерийн сургуулийн
Олон улсын тээврийн менежментийн анги
3-р курсын оюутан Б.НАМУУН*

Өнөөдөр манай улс 1,566.6 км квадрат газар нутагтай, 2.8 сая хүн амтай боловч түүнээс 1.3 сая нь 4,704.4 км квадрат газар нутагтай нийслэл Улаанбаатар хотдоо оршин суудаг. Хотын төлөвлөлтөнд анх тусгагдснаас хэт давсан хүн ам нь ус, хөрс, агаарын бохирдол нь аюулын түвшинд хүрэх үндсэн нөхцөл болсон. Гэтэл зарим хөдөө орон нутагт очиход сааралтсан гудамжуудад нь өдрийн од мэт үзэгдэх хэдхэн хүн, хааяа нэг согтууруулах ундааны гашуун үнэр ханхлуулсан залуус мотоцикл унан давхилдаж тэр өдрөө л хэрхэн өнгөрөөхөө ярилцсан хэдэн хөгшчүүлийн амны бай болно. Энэ л дүр зураг Өмнийн говьд ч бас саяхныг хүртэл үргэлжилсэн.

Хүмүүс Өмнөговь руу явж тэнд ажиллаж амьдрах хүсэл нь улам л нэмэгджээ. Арга ч үгүй биз. Жишээ болгож дурдахад миний авга ах Өмнөговийн уугуул оршин суугч юм. Хөдөөнөөс хот руу шилжин ирсэн мянга мянган хүмүүсийн нэг болж эхнэртэйгээ хотод ирээд ажилгүйчүүдийн эгнээнд элссэн юм. Энд хувийн бизнес хийхээр оролдсон боловч татварын дарамт, хөрөнгө санхүүгийн дутмаг байдлаасаа болоод хэд хэдэн удаа бүтэлгүйтсэн юм. Тэр үеэр Оюу Толгой төсөл Өмнөговьд хэрэгжиж эхэлсэн бөгөөд ах маань ажилд орох талаар ихэд сонирхон, уул уурхайн чиглэлээр их сургуульд суралцах сургалтын төлбөр олохоор хичээж байлаа. Гэтэл нэг жилийн хугацаатай Оюу Толгойн ажилтан бэлтгэх сургалт явагдаж байгаа мөн төлбөр авах бус харин ч цалинтай, төгсөөд баталгаатай ажлын байртай болох талаар сонсоод ах маань маргааш нь л очиж бүртгүүлэн сургалтанд суухаар болов. Төгсөөд Оюу Толгойд ажиллахад хаана амьдрах талаар ах маань их санаа зовж байлаа. Тэндээ ойрхон хашаа байшин түрээслээд яаж ийгээд л амьдрана даа гэж ярьж байсныг нь би санадаг юм. Оюу Толгойд ажилтан болж очоод хэсэг хугацааны дараа эхнэрийгээ тийшээ авч явахаар хотод ирээд бидэнд Өмнөговь аймагт бүтээн байгуулалт хэрхэн явагдаж нүднийх нь өмнө цэцэглэн хөгжиж байгаа талаар, мөн ажлын орчин сайтай, ажилчдын нийгмийн асуудал, чөлөөт цаг, эрүүл мэндэд хэрхэн анхаардаг талаар бараг нүдэнд харагдтал ярьж өгөв. Мөн аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж ажилдаа орохынхоо өмнө ямар хувцас хэрэглэл өмсөх ёстой зэрэг сонирхолтой зүйлсийг надад ярьж өгөн, өмнө бизнес нь бүтэлгүйтэн гуниглаж суудаг байсан ахын минь нүд нь гялалзан баяр хөөртэйгээр ярьж байсан нь одоо ч сэтгэлд минь тод үлдсэн. Тэд удалгүй хүүхэдтэй болж амьдрал нь улам гэрэлтэй болж байгаа тухай ярихын хажуугаар Оюу Толгой компани залуу гэр бүлийг дэмжин орон сууцаар хангасан талаар бас дуулгав. Тэр үед би хөдөө орон нутагт уурхай байгуулагдаж байгаль орчныг л сүйтгэдэг гэж боддог бол нийгмийн хариуцлагыг ухамсарлан, хүмүүсийн нийгмийн асуудал, байгаль орчны нөхөн сэргээлтэнд анхаарч ажиллаж чадвал харин ч хотын төвлөрлийг багасгаж хөдөөг хөгжилд хөтлөх зөв алхам болох юм байна гэж бодох болсон юм.

Одоо харахад Оюу Толгой компани нь 8,000 Монгол хүний амьдралд ахынх шиг минь гэрэл гэгээ авчирч, түүгээр ч үл барам нийгмийн бүхий л талбарт өөрийн хувь нэмрээ оруулж, тэр дундаа улс орны хамгийн үнэ цэнэтэй капитал болох оюутан залууст хөрөнгө оруулалт хийж тэтгэлэг олгодог, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд байгуулдаг зэрэг нь Монголын ирээдүйг гэрэлтэй байлгахад Оюу Толгой компанийн хувь нэмрийг үнэлэгдэшгүй их болгодог гэж би боддог.